

ЦОЧРОЛД ХАРИУ ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН ХАМГААЛАЛ: КОВИД 19-ИЙН СУРГАМЖ БА БОДЛОГЫН ҮР ДАГАВАР

Энэхүү бодлогын тойм нь нийгмийн халамжийн асуудлаарх мэдлэгийн цуврал бүтээгдэхүүний нэг хэсэг бөгөөд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран хэрэгжүүлж буй үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавх бэхжүүлэх АХБ-ны техник туслалцааны (ТА 9893-МОН) төслийн хүрээнд Оксфорд Полиси Менежмент (Их Британи), Хүүхдийн төлөө Түншлэл (Гүрж), Хүн амын Сургалт, Судалгааны Төв (Монгол) -ийн мэргэжилтнүүдийн баг Азийн Хөгжлийн Банкны (АХБ) -ны нийгмийн хамгааллын салбарын мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулав.

Бэлтгэсэн: **Людовико Карраро**, Нийгмийн ухааны доктор, Эдийн засгийн Ухааны доктор, Англи улсын Оксфорд Полиси Менежмент зөвлөх байгууллагын тэргүүлэх зөвлөх

Энэхүү бодлогын хураангуй тоймд 2020 онд цар тахлын нөлөөгөөр үүссэн эдийн засгийн хямралыг даван туулахын тулд Монгол Улсад нийгмийн хамгааллын системийг хэрхэн ашиглах, цаашид хэрэгжүүлэх бодлогын талаар тусгасан болно.

ГОЛ АГУУЛГА

- Нийгмийн хамгааллын системийг ашиглан хүн амын дийлэнх хэсэгт нөлөөлж байгаа цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгаалал нь гамшгийн эрсдэлийн удирдлагын нэг хэсэг юм.
- Монгол Улсад Ковид 19-ийн эсрэг хариу арга хэмжээ авахад нийгмийн хамгаалал чухал үүрэг гүйцэтгэснээс гадна ядуурал нэмэгдэхээс сэргийлж, богино хугацаанд хямралаас эргэж сэргэх үндэс болсон.
- Улс орон хямралаас аажмаар эргэн сэргэхийн хэрээр хямралд нэрвэгдсэн хэвээр байгаа салбаруудаа дэмжих бодлогын арга хэмжээг авах хэрэгтэй. Хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогоор хувилбарт ажлын байранд шилжихийг дэмжих хэрэгтэй.
- КОВИД-19-өөс гадна ган, зуд, макро эдийн засгийн цочрол зэрэг давтагддаг хямралын үед хариу арга хэмжээ авах илүү сайн систем шаардлагатай.
- Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын сайн системийг бий болгохын тулд хууль тогтоомж болон санхүүжилтийн зохицуулалтыг сайжруулах, яаралтай арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх институцийн чадавхийг бэхжүүлэх шаардлагатай.

Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгаалал гэж юу вэ?

Цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгаалал (ЦХҮНХ) гэдэг нь ковариатын цочролын нөлөөллийг бууруулах, түүнд бэлэн байх, үр дагаварт хариу үйлдэл үзүүлэх нийгмийн хамгааллын системийн хэрэглээ юм. Ковариатын шок бол нийгэмд бүхэлд нь нөлөөлөх гадны том цочрол юм.³⁹

Гадаад, том хэмжээний цочролын үндсэн ялгаа нь хувь хүн болон өрхийн түвшинд хүмүүст нөлөөлөх хандлагатай эсвэл амьдралын нэг хэсэг (жишээ нь насжилт гэх мэт) учраас тодорхой хэмжээгээр урьдчилан таамаглах боломжтой байдаг. Уламжлал ёсоор нийгмийн хамгаалал нь амьдралын туршид эмзэг байдлыг арилгах замаар хувь хүн болон өрхийн түвшинд цочролыг даван туулахад тусалдаг. Гэсэн хэдий ч байгалийн гамшгийн давтамж нэмэгдэж байгаа нь улс орон, бүс нутгуудад нөлөөлж буй гэнэтийн хямралд хариу арга хэмжээ авах сайн арга замыг боловсруулахыг шаардаж байна.

Олон улс оронд онцгой байдлын үед авах хариу арга хэмжээг гамшгийн эрсдэлийн удирдлага (ГЭУ)-ын нэг хэсэг гэж авч үздэг бол заримдаа хүмүүнлэгийн тусламж байдлаар хэрэгжүүлдэг. ЦХҮНХ нь гамшгийн эрсдэлийн удирдлага болон хүмүүнлэгийн тусламжийг орлохгүй боловч тэдгээрийг нөхөх нэг арга зам юм.

³⁹ Oxford Policy Management. 2015. Shock-Responsive Social Protection Systems Research Working Paper 1: Conceptualising Shock-Responsive Social Protection. Oxford.

Гамшгийн эсрэг нийгмийн хамгааллыг 2 үндсэн арга замаар хэрэгжүүлж болно: 1) гамшгийн өмнө өрхүүдэд тэсвэртэй байдлыг бий болгох, 2) гамшигт нэрвэгдсэн өрхүүдэд дэмжлэг үзүүлэх, гамшгийн дараа аюултай стратеги ашиглахаас урьдчилан сэргийлэх.⁴⁰

Гамшгийн дараа цочролын эсрэг нийгмийн хамгааллын хариу арга хэмжээг дараах / босоо болон хэвтээ тэлэлт/ арга замаар хэрэгжүүлснээр яаралтай болон эргэн сэргэх үе шатанд хүрэхэд дэмжлэг үзүүлдэг:

- **БОСОО ТЭЛЭЛТ:** нийгмийн хамгааллын хөтөлбөрт хамрагдаж байгаа үр шим хүртэгчдэд тодорхой хугацаанд нэмэлт дэмжлэг үзүүлэх, жишээ нь: бэлэн мөнгөний шилжүүлэг
- **ХЭВТЭЭ ТЭЛЭЛТ:** одоо байгаа хөтөлбөрийг ашиглан үр шим хүртэгчдийг нэмэгдүүлэн тодорхой хугацаанд олон хүнд хүргэх (түр хугацаагаар өргөжүүлэх) эсвэл шинэ хөтөлбөр боловсруулах.

Ном товхимолд нийгмийн хамгааллын дотроос нийгмийн халамжийн үүрэг ролийг онцгойлон авч үзсэн байдаг боловч бид нийгмийн хамгааллын талаар дэлгэрэнгүй ярих шаардлагатай. Яагаад гэвэл цочролд хариу үзүүлэх арга хэмжээнд нийгмийн хамгааллын 3 бүрэлдэхүүн хэсэг болох нийгмийн даатгал, нийгмийн халамж, хөдөлмөрийн зах зээлийн арга хэмжээг багтаасан байх ёстой. Эдгээрийг тухайн орны нөхцөл байдал, хямралын шинж байдлаас шалтгаалан хэрэглэнэ.

Эцэст нь, цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын хөтөлбөрийг үр ашигтай болгохын тулд улс орнууд хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай үндсэн элементүүд буюу хууль тогтоомж, эрх зүйн зохицуулалт, санхүүжилт, үр ашиг хүртэгчдийг тодорхойлох, үр ашгийг түгээх механизм зэргийг сайжруулж хөгжүүлэх шаардлагатай.

КОВИД-19-Д ҮЗҮҮЛЭХ МОНГОЛ УЛСЫН ХАРИУ АРГА ХЭМЖЭЭ

Ковид-19 цартахал нь урьд өмнө гарч байгаагүй дэлхийн цочрол байсан бөгөөд хямралын эдийн засгийн сөрөг нөлөөг бууруулах үндсэн хэрэгсэл нь нийгмийн хамгаалал байсан юм. Дийлэнх улс орнууд Ковид-19-ийн эсрэг

нийгмийн хамгааллын арга хэмжээг 2020 онд баталсан. Нийгмийн тусламжийн арга хэмжээ (бэлэн мөнгөний шилжүүлэг, хэрэглээний төлбөрийн чөлөөлөлт, мөнгөн бус шилжүүлэг) хамгийн түгээмэл байсан бол нийгмийн даатгалын арга хэрэгслүүд (ажилгүйдлийн тэтгэмж, цалинтай өвчний чөлөө, нийгмийн даатгалын шимтгэлийг чөлөөлөх, бууруулах эсвэл хойшлуулах) болон хөдөлмөрийн зах зээлийн бодлого (тухайлбал, цалингийн татаас, хөдөлмөрийн зохицуулалт)-ыг мөн авч хэрэгжүүлсэн байна. Ихэнх хариу арга хэмжээ нь хэвтээ тэлэлтийн арга хэмжээ байдаг ба шинэ хөтөлбөрийг багтаасан байдаг.⁴¹

Монгол Улсын Засгийн газраас нийгмийн хамгааллын томоохон хариу арга хэмжээ авсан. Нийгмийн халамжийн арга хэмжээнд хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээг хүүхэд бүрд сард 20,000 төгрөг (7\$) олгож байсныг 2020 оны 4 дүгээр сараас 100,000 төгрөг (35\$) болгон нэмэгдүүлсэн. Тус арга хэмжээг энэ оны 12 сарыг дуустал хэрэгжүүлнэ. Бусад хариу арга хэмжээний хүрээнд нийгмийн халамжийн тэтгэвэр болон хүнсний эрхийн бичгийн мөнгөн дүнг нэмэгдүүлсэн, малчдад ноолуурын үнийн татаас олгосон байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн чөлөөлөлтийг нийгмийн даатгалын хариу арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Засгийн газар хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрөөр дамжуулан 5 монгол хүн тутмын 4 (хүүхэдтэй өрхөд амьдардаг өрхийн бүх гишүүд)-д нь шууд болон шууд бусаар хүрч чадсан. Хямралын нөлөө өргөн тархсан, хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хөтөлбөрийг ашиглан төлбөрийг хурдан шилжүүлэх боломж (хүүхдийн нэр дээрх банкны данс руу мөнгийг шууд байршуулах)-той байсан тул энэхүү арга хэмжээ богино хугацаанд амжилттай хэрэгжсэн.

Цочролын үед гамшгийн эсрэг уламжлалт арга хэмжээ авахаас гадна нийгмийн хамгааллын арга хэмжээ авах гол үндэслэл нь өрх болон улс орныг сөрөг үр дагаварт хүргэх, эргэн сэргэх хугацааг уртасгах, аюултай стратеги батлахаас сэргийлж байгаа юм. Тийм учраас энэ нөхцөлд нийгмийн хамгааллын арга хэмжээ нь ёс суртахууны хувьд зөв төдийгүй үр ашигтай үйл ажиллагаа юм.


⁴⁰ Аюултай стратеги нь богино хугацаанд цочролыг даван туулах зорилгоор хүнсний хэрэглээгээ бууруулах, хөрөнгөө зарах гэх мэт өрхүүдийн авдаг арга хэмжээ боловч дунд болон урт хугацаанд хүмүүсийн эрүүл мэнд, хөрөнгө, орлогод сөргөөр нөлөөлдөг.

⁴¹ U. Gentilini, M. Almenfi, and P. Dale. 2020. Social Protection and Jobs Response to COVID-19: A Real-Time Review of Country Measures. Living Paper version 14, December 11

Цочролоос эргэн сэргэх шилжилтийг нийгмийн хамгааллын арга хэмжээтэй болон арга хэмжээ байхгүйгээр Зураг 1-д хялбарчлан дүрслэн үзүүлэв. Хэрэв хүмүүс хямралыг даван туулах чадвар дутмаг, ядууралд өртөн, сөрөг стратеги (үйлдвэрлэлийн үндсэн хөрөнгөө борлуулах гэх зэрэг) хэрэгжүүлэхээс өөр арга замгүй бол энэ нь дундаас урт хугацааны үр дагаварт хүргэж болзошгүй юм. Тухайлбал,

Монгол Улсад хийсэн панел судалгаагаар зуд нь малчин өрхийн хүүхдүүдийн өсөлтийн явцыг удаашруулж, үүнээс гарах сөрөг үр дагавар нь цочролоос хойш 3-4 жилийн дараа ч мэдэгдэхүйц хэвээр байгааг харуулжээ.⁴² Эсрэгээрээ, нийгмийн хамгааллын арга хэмжээгээр дамжуулан хэрэглээний түвшинг дэмжвэл илүү хурдан сэргэх боломжтой болно.

Зураг 1. Нийгмийн хамгааллын арга хэмжээ авсан болон аваагүй үеийн цочролоос эргэн сэргэх шилжилт



Эх үүсвэр: Зохиогчид

Ядуурлын шугамаас доогуур амьжиргаатай хүн амын хувь 2020 онд цар тахлын эдийн засгийн үр нөлөө (хил хаасан, хөл хорио, коронавирусийн тархалтыг бууруулах зорилгоор авсан бусад арга хэмжээ)-ний улмаас 28 хувиас 37 хувь болж нэмэгдэхээр байв.⁴³ Цочролын эсрэг нийгмийн хамгааллын хариу арга хэмжээг цаг алдалгүй авч хэрэгжүүлсэн нь ийм өсөлтөөс сэргийлж, магадгүй ядуурлын түвшинг бууруулсан байж болох юм. Хүүхдийн мөнгө хөтөлбөрийг дангаар нь хэрэгжүүлсэн бол ядуурлын түвшин буурч 25 хувь, нийгмийн хамгааллын бусад арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлсэн бол ядуурлын түвшин буурч 18 хувь болохоор тооцоолсон байна.⁴⁴ Эдгээр үр дүн нь хэд хэдэн таамаглалаас хамааралтай симмуляци

боловч нийгмийн хамгааллын нөлөөгөөр ядуурал нэмэгдэхээс сэргийлж, хямралыг даван туулахад чухал хувь нэмэр оруулж байгааг харуулж байна. Нэмэгдсэн өртгийн албан татварын тоо мэдээллийг ашиглан ядуурал, тэгш бус байдлыг шууд бус аргаар үнэлсэн 2020 оны судалгаагаар нийгмийн хамгааллын арга хэмжээ нь ядууралд эерэг нөлөө үзүүлж байгааг баталсан байна.⁴⁵

Цар тахлаас үүдэлтэй дэлхийн эдийн засгийн уналт олон талаараа онцлог байсан. Цочролын шинж чанар нь хүн амын дийлэнх хувийг тэр дундаа урьд өмнө нь ядуу байгаагүй хүн амыг хамарсан. Энэ нь хүн амын ихэнх хувьд хүрсэн арга хэмжээ нь шинээр бий болсон ядуучуудад хүрэхэд тохиромжтой байна гэсэн үг юм.⁴⁶

⁴² Groppo, V., Kraehnert, K., 2016. Extreme Weather Events and Child Height: Evidence from Mongolia. World Development 86, 59–78.

⁴³ Carraro L. and Tserennadmid A. 2020. Assessment of the social protection response to COVID-19 in Mongolia. Asian Development Bank TA 9893-MON working paper. Manila.

⁴⁴ Өмнөх ишлэлтэй ижил.

⁴⁵ United Nations Development Programme. 2021. Mongolia: Poverty and Inequality during COVID-19 using Big Data. Ulaanbaatar

⁴⁶ Carraro L. and Marzi M. 2021. Better responding to shocks through social protection: COVID-19 insights on identifying and responding to dynamic poverty. Social Protection Approaches to COVID-19 Expert Advice Service (SPACE). DAI Global UK Ltd, United Kingdom

Хүүхдийн мөнгөөр дамжуулан босоо тэлэлт хийж бараг 2 жил болж байгаа нь хэд хэдэн асуудлыг бий болгож байна. Халамжийн мөнгийг нэмэгдүүлсэн нь түр зуурын тусламж гэдгийг тодорхой харуулж чадсан уу? Халамжийн мөнгөний хэмжээ буурахыг хүмүүс хэрхэн хүлээж авах вэ? Эдгээрээс илүү чухал нь нэн яаралтай үеэс шилжилтийн болоод эргэн сэргэх үе рүү шилжихэд ямар стратеги баримтлах вэ гэдэг асуудал юм. Ковид-19 цар тахлын нөхцөл байдал сайжрахаар аялал жуулчлал, зочлох үйлчилгээ гэх мэт цар тахлын нөлөөнд илүү өртсөн салбаруудад анхаарлаа хандуулж, ажиллагчдыг өөр ажил олоход нь дэмжлэг үзүүлэх зэргээр хөдөлмөрийн зах зээлийн идэвхтэй бодлогыг хэрэгжүүлж болох юм. Товчоор хэлэхэд, ЦХҮНХ-ын бодлогыг шинэ нөхцөл байдалд нийцүүлэх хэрэгтэй.

Өөр нэг чухал асуулт бол өнөөгийн нийгмийн хамгааллын хөтөлбөрийг ашиглах нь цочролд шууд өртсөн хүн амыг зөв онилж байгаа эсэх асуудал юм. Хүүхдийн мөнгөн тэтгэмж хөтөлбөрийн хүрээнд бүх хүүхдэд олгож байгаа мөнгөний хэмжээг нэмэгдүүлсэн нь цар тахлын хариу арга хэмжээ болгож богино хугацаанд авч хэрэгжүүлсэн зөв бодлого боловч, энэ нь байнга хамгийн сайн хувилбар байж чадахгүй. Зуд гэх мэт ирээдүйд учирч болзошгүй цочрол нь хүн амын тодорхой бүлэгт илүү нөлөөлнө. Энэ нь ГЭУ-ын зэрэгцээ цочролын хариу арга хэмжээнд зориулсан нийгмийн хамгааллын хөтөлбөрийн нийцтэй байдалд өргөн хүрээг хамарсан үнэлгээ хийх шаардлагатайг харуулж байна. Цар тахлаас өмнө НҮБ-ын Хүүхдийн Сангаас *Завхан аймагт* хамгийн их эрсдэлтэй сумдыг тодорхойлж, зудын сөрөг үр дагавраас сэргийлэх зорилгоор хэрэгжүүлсэн туршилтын төслөөр хямралын хариу арга хэмжээний бэлтгэлийг хангахад дэмжлэг үзүүлж, зудаас болж өргөжүүлсэн жагсаалтад орсон сумдад бодит дэмжлэг үзүүлсэн⁴⁷. Туршилтаар 5 хүртэлх насны хүүхдийн ХТМ-ийг нэмэгдүүлж, төлбөр бүрийн дараа хуваарилалтын дараах хяналтын судалгаа явуулсан. Энэ нь бүрэн хэмжээний үнэлгээ биш боловч Монголд давтагддаг цочролд үзүүлэх хариу арга хэмжээний системийг сайжруулахад хэрэгцээтэй мэдээллээр хангаж, судалгааны явцад төдийгүй бэлтгэл ажилд дэмжлэг үзүүлсэн.

Монгол Улсад байнга давтагддаг цочрол: Үүний эсрэг стратеги бий юу?

Дэлхийн зах зээл дээр эрдэс бүтээгдэхүүн, түүхий эдийн үнийн хэлбэлзэл, *зудын* улмаас байнга давтагдаж байгаа цочролын улмаас макро эдийн засгийн томоохон цочролыг бий болгодог тул дээр дурдсан асуултууд Монгол Улсад хамааралтай юм. Монгол Улсын хүн амын томоохон хувь нь мал аж ахуй эрхэлдэг бөгөөд цаг агаарын хатуу ширүүн уур амьсгал нь мал аж ахуйн салбарт ихээхэн нөлөө үзүүлэх хандлагатай байдаг. Зуд нь мал сүргийн тоо толгойг шууд хорогдуулахаас гадна үнийн огцом өөрчлөлтийг бий болгодог. Цаг агаарын эрс тэс үзэгдлүүдийн давтамж цаашид нэмэгдэх төлөвтэй байгаа бөгөөд уур амьсгалын өөрчлөлтийн таамаглалаар мал аж ахуйн салбарт сөргөөр нөлөөлөхөөр байна.

Монгол Улсын Онцгой байдлын ерөнхий газар (ОБЕГ) нь гамшгийн эрсдэлийн удирдлагын чухал үүргийг гүйцэтгэдэг боловч үйл ажиллагааны чиглэл нь хязгаарлагдмал байдаг. Гол төлөв онцгой байдлын үед хариу арга хэмжээ авах үүрэг гүйцэтгэж, малын хорогдол зэрэг шууд алдагдалд анхаарлаа хандуулдаг. Харин зудын үр дагавар нь инфляцийн дарамтаас үүдэлтэй шууд бус нөлөөтэй байдаг. Энэ хүрээнд нийгмийн хамгаалал нь онцгой байдлын хариу арга хэмжээ авахаас гадна гамшигт өртсөн өрхүүдийг эргэн сэргэхэд дэмжлэг үзүүлэх маш чухал үүрэг гүйцэтгэх боломжтой юм.

ЦХҮНХ-д үр дүн, цаг хугацаа маш чухал бөгөөд цочрол болохоос өмнө сайн бэлтгэлтэй байснаар үүнд хүрэх боломжтой. Энэ нь санхүүжилтийн тогтолцооноос гадна нийгмийн хамгааллын хэрэгцээний дагуу хариу үйлдэл үзүүлэхийг зөвшөөрсөн, халамжид хамрагдах шаардлагатай иргэдийг олж тогтоон, халамжийг хүргэх системийн хууль эрх зүйн орчинг бий болгоно гэсэн үг юм. Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомжид зааснаар хямралыг даван туулахад нийгмийн хамгааллын хэрэгслийг уян хатан ашиглах боломжгүй бөгөөд КОВИД-19-ийн эсрэг хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхийн тулд энэ талаарх заалтыг хуульд оруулж батлуулах шаардлагатай.⁴⁸ Дахин давтагдах цочролын

⁴⁷ UNICEF 2020. Summary of shock-responsive social protection programme pilot for rural children. Ulaanbaatar

⁴⁸ Enkhtsetseg Byambaa et al. 2019. Exploring the potential for using shock responsive social protection in Mongolia. Report prepared for the World Food Programme. Ulaanbaatar. Unpublished.

үед тусламж хэрэгтэй байгаа хүмүүст туслах нийгмийн хамгааллын одоогийн системийг ашиглах боломжийг олгох шаардлага байгаа тул үүнийг холбогдох хууль тогтоомжид зарим өөрчлөлтийг оруулах замаар ихээхэн хөнгөвчлөх боломжтой юм. Хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах нь цочрол гарсан тохиолдолд илүү сайн санхүүжилт хийх боломжийг бүрдүүлэх юм. Учир нь одоогоор зөвхөн ОБЕГ болон орон нутгийн засаг захиргаа нөөц хөрөнгийг зарцуулах эрхтэй байдаг. Монгол Улс хүн амынхаа дийлэнх хувийг хамарсан өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлсэн нь томоохон давуу тал юм. Энэхүү мэдээллийн санг хүнсний эрхийн бичиг олгох ядуу өрхүүдийг тодорхойлоход ашигладагаас гадна мэдээллийн санд бүртгүүлэх нь ХМТ хөтөлбөрт хамрагдах урьдчилсан нөхцөл болдог. Мөн яаралтай тусламжийн хөтөлбөрийг мэдээллээр хангах үндсэн эх үүсвэр юм. Энэхүү мэдээллийг яаралтай тусламжийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шатанд тухайлбал хэрэгцээний үнэлгээ хийх, тэтгэмжийн хэмжээ, төлбөрийн систем, харилцаа холбоо, гомдол хүлээн авах зэрэгт

хэрхэн ашиглах талаар урьдчилан төлөвлөх нь чухал юм. Түүнчлэн НҮБ-ын Хүүхдийн сангийн туршилтын судалгаанд дурьдсанаар цочрол болохоос өмнө ялангуяа эрсдэлтэй бүс нутагт урьдчилан сэргийлэх төлбөрийг ашиглах талаар авч үзэх хэрэгтэй.

ЦХҮНХ-ын үр дүнтэй системд шилжих нь

Монгол Улсад Ковид-19-д үзүүлсэн хариу үйлдэл нь цочролд хариу үзүүлэх нийгмийн хамгааллын ач холбогдлыг харуулсан. Иргэдэд шаардлагатай дэмжлэг тусалцааг цаг алдалгүй хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх нь нь хямралын үр нөлөөг бууруулж, түргэн сэргэх боломжийг олгодог. Гэсэн хэдий ч зуд гэх мэт байнга давтагддаг цочролд хариу үзүүлэхэд нийгмийн хамгааллыг ашиглах боломжийн талаар авч үзэхэд анхаарах чухал сургамжууд байна. Эдгээрийг ЦХҮНХ-ын үр дүнтэй системийг бий болгох үндсэн бүрэлдэхүүн хэсгүүд болон түүнийг боловсруулахад зөвлөмж болгож буй үйл ажиллагаануудыг доорх хүснэгтэд тоймлон харуулсан. Үүнд:

ЦХҮНХ-ын системийн бүрэлдэхүүн хэсгүүд	Зөвлөмж болгож буй үйл ажиллагаа
Хууль эрх зүй, зохицуулалтын хүрээнд	- Нийгмийн халамжийн тухай хуульд нийгмийн хамгааллыг цочролын хариу үйлдэл үзүүлэх хэрэгсэл болгон ашиглах талаар оруулах
Санхүүжилтийн төлөвлөгөө	- Нийгмийн хамгааллын яаралтай хариу үйлдэл үзүүлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх санхүүжилтийн төлөвлөгөөг боловсруулах, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам нөөц санг ашиглах
Цочролд өртөж үр шим хүртэгчдийг тодорхойлох систем	- Олон улсын санхүүгийн байгууллагуудтай цочролын нөхцөл байдлаас хамааран яаралтай хэрэгжүүлж болохуйц санхүүжилтийн гэрээ байгуулах боломжийг судлах
Цочролд өртөж үр шим хүртэгчдийг тодорхойлох систем	- Өрхийн бэлэн байдлыг дэмжих тэтгэмж олгохын тулд өрхийн мэдээллийн нэгдсэн санг цочролын үед болон цочролын өмнө үр шим хүртэгчдийг тодорхойлох хамгийн тохиромжтой мэдээллийн систем болгон бэхжүүлэх
ЦХҮНХ-ын шийдлийг ашиглах бэлтгэл ажил	- Мэдээллийн сангийн байнга өөрчлөгдөх хэрэгцээний үнэлгээг хийх, мэдээллийг үр дүнтэй ашиглахад хөрөнгө оруулалт хийх
ЦХҮНХ-ын шийдлийг ашиглах бэлтгэл ажил	- Мэдээллийн сангийн чанар болон өртгийг баталгаажуулахын тулд хөтөлбөр хоорондын хэрэглээг нэмэгдүүлэх
ЦХҮНХ-ын шийдлийг ашиглах бэлтгэл ажил	- Цочрол болохоос өмнө яаралтай хөтөлбөрийн үндсэн загварыг тодорхойлохдоо хэнийг хамруулах, дэмжлэгийн хугацаа болон хэмжээ зэргийг оруулах
Нийгмийн хамгааллын яаралтай тусламжийн олголт	- ЦХҮНХ-ын арга хэрэгслийг яаралтай ашиглах
Нийгмийн хамгааллын яаралтай тусламжийн олголт	- Кампанит ажлыг эхлүүлэх
	- Монголд халамжийн мөнгийг цахимаар дансанд нь шилжүүлэх систем бүрдсэн хэдий ч шууд авч хэрэглэж болох, хадгаламжийн дансанд түгжигдэхгүй байх, түүнчлэн интернет банк хэрэглэх боломжийг олгоход анхаарах